



Онцгой Хүрэм

ИВЭЭЛ Их Эзэн биднийг мэддэг бөгөөд бидэнд санаа тавьдаг.

Унших Зүйл

Эхлэл 37:1-11; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 208-210.

Цээжлэх Ишлэл

“Их Эзэн өөрөөс нь гуйсан хүн бүрт сайныг өгнө. (Матай 7:11).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Бидний ухаан бодлыг чиглүүлж бидэнд эцэг, эх өгснөөрөө Их Эзэн өөрийн хайраа харуулж байдаг гэдгийг **мэдэх** болно.

Их Эзэнээр хайрлагдсан гэдгээ **мэдрэх** болно.

Сайн оюун бодол болон эцэг эх өгсөнд нь Их Эзэнд **талархаж байх** болно.

Гол Санаа



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Иосеф Иаковын хамгийн хайртай хүү нь бөгөөд хайртай эхнэр Рахелаас төрсөн болохоор Иаков ихэд хайрладаг байлаа. Иосеф эцгийнхээ үгэнд ордог бөгөөд зүрх сэтгэл нь цэвэр ариун учир эцгийнхээ баяр хөөр нь байв. Ихэвчлэн алдартай хүмүүсийн өмсдөг үнэтэй хүрмийг аав нь Иосефт өгчээ. Энэ бүхнээс болоод арван ах нь түүнд их атаархдаг байжээ. Ах нар нь Иосефын сагсуу хөөргөн мөрөөдөлд нь болон өөрсдийг нь аавдаа ховлочихдог байсанд нь тун дургүй байв.

Энэ бол ивээлийн тухай хичээл

Их Эзэн бидэнд сайн бэлгийг өгөх дуртай. Их Эзэн Иосефт сайн аав өгсөн шиг бидэнд ч мөн сайн ах эгч дүүг өгдөг. Их Эзэн Иосефт сайхан мөрөөдөл өгсөн шиг бидний оюун бодлыг зөв чигт чиглүүлж байдаг.

Багшийн Баяжуулалт

"Зүс царай нь сайхны дээр сэтгэл зүрх оюун ухаан нь цэвэр ариун нэгэн хүү байжээ. Тэр Рахелын ууган хүү. Идэвхтэй, цэвэр ариун, баяр баясгалантай байдал нь түүний ёс суртахууны зөвт байдлыг харуулж

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Иосефын Эрээн Хүрэм</i> <i>Б. Зөвхөн Ганцхан Өнгө</i>	байхгүй өнгийн харандаа, будах зураг (144-р хуудас)
* Залбирал ба Магтаал*	10 минут	93-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	өнгөлөг нөмрөг, хүрэм эсвэл цамц, цүнх
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>А. Бурханы Бэлэг</i> <i>Б. Ертөнцийг Хараач</i>	бэлэгний хайрцаг, олон янзын зураг эсвэл эд зүйлс <i>Бяцхан хүүхдүүд Түүнийг магт дууны ном, самбар, шохой</i>
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Тансаг Хүрэм</i>	хүрэмний загвар (145-р хуудас) цаас, хайч, харандаа, зургийн хэрэгсэл, цавуу

чадсан юм. Тэр эцгийнхээ үгийг сонсдог ба Их Эзэний үгэнд орох дуртай. Египетэд очсоных нь дараа ялгарч гарч ирсэн өгөөмөр, эрхэмсэг, үнэнч зан чанар нь түүний өдөр тутмын амьдралыг илтгэж байдаг. Түүний ээж багад нь нас барсан учир тэрээр аавтайгаа нэлээн ойр дотно байсан бөгөөд аав нь хэдий нас өндөр байсан ч энэ хүүдээ сэтгэл зүрхнээсээ хайртай байсан юм". (*Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 209).

"Түүний энэ цэвэр ариун байдал нь, сүнсний сэргэлт ах нарт нь өөрсдийнх нь гэмт байдлыг санагдуулдаг". (*Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 210).

Иаков нэг хүүхдийг бусдаас нь илүүд үзсэн алдаа хийсэн. Та нар ийм зүйл хийхээс хэрхэн сэргийлж чадах вэ?

Өрөөний Зохион Байгуулалт

Нэгдүгээр хичээл дээр байсан тайзны заслыг хэрэглэ.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Иосефын Эрээн Хүрэм

Хүүхдүүдийг босгоод хэлэх нь: **Та нарыг өнгө хэр сайн мэддэг болон зааврыг хэрхэн дагадгийг одоо бид үзэх гэж байна. Би та нарт ямар нэгэн зүйл хий гэж хэлнэ. Одоо сайн сонс, тэгээд миний хэлснийг хий.**

"Хэрвээ чи цэнхэр хувцас өмссөн байвал суу, хэрвээ чи ногоон хувцас өмссөн байвал толгойгоо гурван удаа ил" гэх мэт заавар өгч хүүхдүүдийн өмссөн хувцасны бүх өнгийг хэлтлээ тоглоомоо үргэлжлүүл.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой. **Та нар маш анхааралтай сонслоо. Та нар өнгө мэдэж байгааг би харлаа. Надтай хамт энэ тоглоомыг тоглоход хөгжилтэй байсан уу?**

Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол хүүдээ эрээн өнгөтэй нэгэн бэлэг өгсөн хүний тухай юм. Та нар хурц өнгөнд дуртай юу? Та нар өнгө өнгийн хувцас өмсөх дуртай юу? Дуртай өнгө чинь юу вэ?

Яагаад та нар Их Эзэн бидэнд олон янзын өнгө өгсөн гэж бодож байна вэ? (Олон зүйл, гоо үзэсгэлэн). Их Эзэн бидэнд олон сайхан бэлэг өгсөн. Өнгө бол тэдгээрийн нэг юм. Бүх зүйл нэг өнгийн байхгүйгээр болж Их Эзэн бидэнд олон янзын өнгө өгсөнд би маш их баяртай байна. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

Хэрэгтэй зүйлс:

- будах зураг (х. 144)
- цаас
- өнгийн харандаа

Б. Зөвхөн Ганцхан Өнгө

Хүүхэд бүрт будах зураг (144-р хуудас) болон өнгийн харандааг өг. Тэгээд зөвхөн ганцхан өнгөөр буд гэж хүүхдүүдэд хэлээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой. **Асуух: Би та нарын будсан зургийг харж болох уу? Та нар үүндээ дуртай байна уу? Яагаад та нар үүндээ дургүй байна гэж? Зөвхөн ганцхан өнгө ашиглах нь**

хэцүү байна уу? Яагаад та нар нэгээс илүү тооны өнгө хэрэглэхийг хүссэн бэ?

Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол хүүдээ өнгө алагласан нэгэн бэлэг өгсөн хүний тухай юм. Та нар хурц өнгөнд дуртай юу? Та нар гоё өнгөтэй хувцас өмсөх дуртай юу? Дуртай өнгө чинь юу вэ?

Яагаад та нар Их Эзэн бидэнд зориулж өнгө бүтээсэн гэж бодож байна? (олон зүйл ялгарал, гоо үзэсгэлэн). Их Эзэн бидэнд олон сайхан бэлэг өгсөн. Өнгө бол тэдгээрийн нэг юм. Бүх зүйл нэг өнгийн байхгүйгээр болж Их Эзэн бидэнд олон янзын өнгө өгсөнд би маш их баяртай байна. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

"Өнгө" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 159*)

"Бэлэг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 80*)

"Хар, хар, ертөнцийг хар" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 78*)

"Талархлын дуу" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 245*)

"Миний гэр бүл" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 253*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй. Асуух:

Өнөөдрийн түүхэнд Их Эзэн хүмүүст хайраа хэрхэн харуулж байна вэ?

Хандив

Хэлэх: Их Эзэн бидэнд олон сайн бэлэг өгдөг. Хэн заримыг нь нэрлэж чадах вэ? Бүгдээрээ бусадтай өргөлөө хуваалцсанаараа Их Эзэнд баярлалаа хэмээн хэлцгээе.

Залбирал

Их Эзэний бидэнд өгсөн бүхий л сайн сайхан бэлэгнийх нь төлөө Түүнд талархаарай.

* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхийн Танилцуулга

Хэрэгтэй зүйлс:

- эрэн өнгийн нөмрөг
- хүрэм эсвэл цамц
- цүнх

Цүнхэндээ эрэн өнгийн нөмрөг хүрэм эсвэл цамц хийсэн түүхийг өгүүлэх хүн хэрэгтэй.

Түүхийг ярьж эсвэл уншиж өгөх

Иосеф маш өнөр гэр бүлтэй байжээ. Түүнд олон ах эгч нар байсан. Та нарт ах эгч бий юу? Хэд байдаг вэ? Иосефт хэдэн эгч байсныг би мэдэхгүй боловч түүнд 11 ах байжээ. 11 хүртэл тоолж

чадах уу? *[Тоолох.]* Түүнд 10 том ах нэг дүү байсан ба тэд бүгд хоньчид. Хоньчид юу хийдгийг мэдэх хүн байна уу? Хоньчид хонио хариулдаг юм. Хонь яаж дуугардаг вэ?

Иосефын ээж нь түүний дүүг гаргаад нас баржээ. Иосефын аавыг Иаков гэдэг байсан. Иаков бүх хүүдээ хайртай хэдий ч Иосефт илүү хайртай байжээ. Учир нь Иосеф түүнд баяр баясгалан төрүүлдэг юм. Аавыгаа ийм өндөр настай байхад Иосеф түүнийг янз бүрээр баярлуулдаг байв.

Нэг өдөр Иосефын аав нь түүнд нэг гоё хувцас өгчээ. Энэ бол түүний харж байсан хамгийн гоё хувцас байлаа. *[Цүнхнээс хувцсыг гарган ирэх ба хүн бүр түүнийг барьж үзэж.]* Энэ маш гоёмсог чамин бөгөөд хэн нэгэн чухал хүний өмсдөг хувцас шиг л харагдана. Иаков хүүдээ бэлэг өгөхийг хүссэн боловч энэ нь зөвхөн Иосефын ах нарын атаархлыг төрүүлжээ.

Нэг шөнө Иосеф зүүд зүүдэллээ. Тэр зүүднийхээ тухай ах нар болон аавдаа хэлдэг. Зүүд гэж юу болохыг мэдэх хүн байна уу? *[Энэ нь яг л унтаж байхдаа толгойндоо зураг харах шиг.]*

Иосеф ах нартайгаа хамт тариалангийн талбайд үр тариаг багцлан боож байна гэж зүүдлэжээ. Иосефын боодолтой тариа зогсоод *[Иосефын боодолтой тариа шиг босож зогс.]* Ах нарынх нь боодолтой тарианууд түүний урд бөхийн ёслож байна гэнэ. Ах нарынх

нь зөөлөн багц тариа шиг бүгд унана. *[Хүүхдүүдэд хугацаа өгөн дараа нь суулгаж болно.]*

Иосеф өөр нэгэн зүүд зүүдлэв. Энэ зүүд нь яг өмнөх шиг нь боловч энэ удаа нар, сар 11 одод байжээ. Энэ зүүд нь Иосефын ах нарыг ихэд уурлуулав. Тэд Иосефоос "Бид бүгд чиний өмнө бөхийн ёслоно гэж чи хэлэх гээд байна уу?" хэмээн асууна. Иосеф зүүдээ ойлгоогүй. Хэн ч энэ зүүдийг ойлгоогүй бөгөөд дургүй байгаагаа л мэдэж байв.

Их Эзэн Иосефыг олон сайн бэлгээр ивээсэн. Их Эзэн түүнд өөрт нь маш их хайртай эцэг эхийг өгсөн. Хэзээ нэгэн өдөр их чухал болох зүүдийг ч Их Эзэн түүнд өгсөн юм. Гэвч Иосефын ах нар түүнд их атаархан түүнд сайн хандахгүй байлаа. Иосеф тэдний тухай мууг санаж болох байсан ч Их Эзэн түүнд сайн бодлуудыг өгчээ. Иосеф бусдыг хайрлаж, үгэнд орж, найрсаг байж, тусархаг баяр хөөртэй нэгэн байсан.

Бурхан чамд ч мөн олон сайн бэлэг өгдөг билээ. Чамд хайртай гэр бүлийг чинь Тэр чамд өгсөн. Тэр та нарт мөн сайн бодлуудыг ч өгч болох бөгөөд тэр нь найрсаг байх тэвчээртэй хандах зэрэг юм. Та нар зөвт зүйл хийхийг хүсэж байна уу? Та нар Бурханд хайртай юу?

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Иосефт аав нь онцгой хүрэм өгөхөд нь тэр ямар байсан бэ? Иосефын мөрөөдөл аав болон ах нарт нь ямар санагдсан бэ? Ах нарыгаа өөрт нь атаархаж байхад Иосефт ямар байсан бэ?**

Их Эзэн Иосефт яагаад мөрөөдөл өгсөн бэ? Их Эзэн бидэнд сайн бэлэг өгдөгт нь би маш их баяртай байна. Санагтун:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:

Библи

Библиэ нээгээд Библийнхээ Эхлэл 37:1-11-г гарган "Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн

маань энэ хэсэгт байна" гэж хэлээд ишлэлийг чангаар уншаарай.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Иосеф яагаад эцгийнхээ хамгаас хайртай хүү нь байсан бэ? Иосефын аав түүнд юу өгсөн бэ? Энэ нь түүний ах нарт ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?**

Иосефт ямар хоёр мөрөөдөл байсан бэ? Тэр өөрөө мөрөөдлийнхөө утгыг мэдэж байсан уу? Иосеф үргэлж юу хийхийг оролдож байсан бэ? Чи ч бас Иосеф шиг байхыг хүсэж байна уу? Санагтун:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Библиэ нээгээд Матай 7:11-г гарган хэлэх нь: **Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна.** Ишлэлийг чангаар унш. **"Их Эзэн өөрөөс нь гуйсан хүн бүрт сайныг өгнө"** Тэгээд цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.

Их Эзэн

Дээшээ заах.



Өөрөөс нь

Дээшээ заах.

гуйсан хүн бүрт

Алгаа залбирч байгаа мэт нийлүүлэх.



сайныг өгнө.

Гараа нийлүүлэн алгаа дээш нь харуулаад хүнээс бэлэг авч буй мэт биеэсээ урагш болгоно.



Матай 7:11

Алгаа нийлүүлээд ном мэт дэлгэнэ.



Хэрэгтэй зүйлс:

Библи

3

Хичээлээ Заах

А. Бурханы Бэлэг

Хэрэгтэй зүйлс:

- бэлэгний хайрцаг
- олон янзын зураг болон эд зүйлс

Юуны өмнө, Бурханы бэлгийг илэрхийлж чадах зураг болон эд зүйлсийг бэлэгний хайрцаг дотор хий (Амьтан, гэр бүл, байгаль, эрүүл чийрэг бие, хайр, гэр орон, хоол хүнс, ус, тусламжтай байдал, тэсвэр тэвчээр, хувцас, цэвэр бодол гэх мэт).

Асуух: **Бурхан та нарт бэлэг өгдөг гэдгийг мэдэх үү? Тэр бэлгүүд үргэлж бэлэгний цаасаар боолгосон эсвэл хайрцагтай ирдэг гэж үү? (Үгүй). Тэр та нарт**

хамгийн сайн бэлгийг өгдөг.

Бурханы та нарт өгсөн зарим бэлгийг нэрлээч. Энэ хайрцагнаас Бурханы бэлгийг гаргаж ирэхэд туслах нэг туслагч надад хэрэгтэй байна. Зүйл бүрийг гаргаж ирэхдээ энэ юуг илэрхийлж байгааг ярилцаарай.

Бататгах нь

Хүүхдэд хариулах боломж олгоорой: **Хүмүүс та нарт хэзээ бэлэг өгдөг вэ? Хэн нэгний чамд өгсөн хамгийн сайн бэлэг юу вэ? Бурханы чамд өгсөн хамгийн сайн бэлэг юу вэ?**

Бурхан чамд маш их хайртай учраас хамгийн сайныг өгч байдаг. Иосефт өгсөн шигээ, Бурхан чамд ч бас хамгийн сайн бэлэг болгож сайн сайхан бодлыг өгсөн гэдгийг мэдэх үү? Хайр, тэсвэр тэвчээр, найрсаг байдал, баяр хөөр, бидэнд сайн бус хандаж байгаа хүмүүст туслах сэтгэл зэрэг юм. Бурхан чамд хайртайг мэдэж байх бэлгийг хүртэл өгсөн шүү дээ. Гол санаагаа санацгаая:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Ертөнцийг Хараач

Хэрэгтэй зүйлс:

- дууны ном
- шохойны эсвэл цагаан самбар
- шохой эсвэл фламастер

Хэлэх: **Бурхан чамд бэлэг өгдөг гэдгийг чи мэдэх үү? Тэр бэлгүүд нь үргэлж бэлэгний цаасаар боолгоостой ирдэг үү? (Үгүй) Бурхан чамд хамгийн сайныг өгдөг. Бурханы чамд өгсөн өөр ямар бэлэг байна вэ?**

Хэрвээ боломжтой бол, ангиараа гадагшаа гарч Бурханы өгсөн

зарим бэлгийг байгалиас олж хараарай.

Энэ дэлхий дээрх Бурханы бидэнд өгсөн бэлэгнүүдийн тухай дуу дуулцгаая. "Хар, хар, ертөнцийг хараач" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 78) дууг дуулаарай. Хүүхдүүдээр шинэ бадаг зохиолгож ч болно.

Бататгах нь

Хүүхдэд хариулах боломж олгоорой: **Хүмүүс чамд хэзээ бэлэг өгдөг вэ? Та нарын авч байсан хамгийн сайхан бэлэг чинь юу вэ? Их Эзэний чамд өгсөн хамгийн сайн бэлэг юу вэ?**

Их Эзэн чамд маш их хайртай учраас хамгийн сайныг өгч байдаг. Иосефт өгсөн шигээ, Их Эзэн чамд ч бас хамгийн сайн бэлэг болгож сайн сайхан бодлыг өгсөн гэдгийг мэдэх үү? Хайр, тэсвэр тэвчээр, найрсаг байдал, баяр хөөр, бидэнд сайн бус хандаж байгаа хүмүүст туслах сэтгэл зэрэг юм. Их Эзэн чамд хайртайг мэдэж байх бэлгийг хүртэл өгсөн шүү дээ. Хичээлийн гол санааг санацгаая:



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Намайг дагаад хэлээрэй.

4

Хичээлээ Хуваалцах нь

Тансаг Хүрэм

Хүүхэд бүрт хүрэмний загвар зургийг хувилж өг. (145-р хуудас). Өнгийн харандаа, даавууны хэсэг, нэхмэлийн утас, товч зэргийг зургийн хэрэглэлдээ хэрэглээрэй.

Хэлэх: **Иосефт аав нь бэлэглэсэн шиг хувцас үүнтэй адил бөгөөд энэ та нарын гоёлын хувцас болох болно. Үүн дээр цээжлэх ишлэл чинь бичигдсэн байгаа. Та нар цээжлэх ишлэлээ санаж байна уу? Одоо хамтдаа уншицгаая: "Их Эзэн өөрөөс нь гуйсан хүн бүрт сайныг өгдөг".**

Бурханы чамд бэлэглэсэн хамгийн сайхан бэлгийг гоёлын хувцасныхаа ард бичихдээ том хүнээс туслалцаа аваарай. Тэгээд гоёлын хувцсаа чимэглээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Их Эзэн Иосефт ямар бэлэг өгсөн бэ?** (Эцэг эх, гэр бүл, мөрөөдөл, сайхан бодол гэх мэт.)

Гоёлын хувцсаа гэр рүүгээ авч яваад энэ долоо хоногт хэн нэгэнтэй хуваалцаарай. Тэгээд хуваалцсан хүндээ Иосефын тухай бас Их Эзэн чамд ямар бэлэгнүүд өгсөн тухай ярьж өгөөрэй. Тэдгээр бэлэгнүүдийг санаж байна уу? (хайрт аав, сайхан бодол).

Гоёлын хувцасныхаа ард нэрийг нь бичсэн Их Эзэний чамд өгсөн хамгийн сайхан бэлэгнийхээ тухай ч бас ярьж өг. Тэгээд энэ долоо хоног санаж яваарай:

Хэрэгтэй зүйлс:

- хүрэмний загвар (х.145)
- цаас
- хайч
- үзэг
- зургийн хэрэглэл
- цавуу



Их Эзэн бидэнд хайртай учраас үргэлж сайныг өгдөг.

Хичээлийн Хаалт

Хэлэх: **Есүс ээ, бидэнд өгсөн бэлэг бүрийн тань төлөө бид танд талархая. Үргэлж танд талархдаг байхад минь туслаач. Бид танд хайртай. Амээн.**

Онцгой Хүрэм

Унших Зүйл

Эхлэл 37:1-11;
Эцэг Өвгөд ба
Зөнчид, х. 208-
210.

Цээжлэх Ишлэл

"Их Эзэн өөрөөс
нь гуйсан хүн
бүрт сайныг
өгнө. (Матай
7:11).

Гол Санаа

**Их Эзэн бидэнд
хайртай учраас
үргэлж сайныг
өгдөг.**

Эцэг эхийнхээ өгсөн хамгийн гоё бэлэгний тухай бод. Иосефын аав нь түүнд онцгой нэгэн бэлэг өгчээ. Их Эзэн ч мөн өгсөн.

Иосеф толгойгоо усанд дүрээд ихэд инээмсэглэн гарч ирлээ. Хүйтэн ус мөн ч гоё байв. Өдөржингөө хонь хариулна гэдэг тоос шороотой холилдож дуусдаг ажил билээ. Иосеф толгойгоо сэгсэрхэд түүний толгойны ус энд тэндгүй үсрэв.

"Хөөе, юу хийж байгаагаа хараач" гэж Реубен ах нь хашгирлаа.

"Энэ Иосеф уу?"

Миний хүү Иосеф хаана байна гэж?" аав нь асуув.

Иаков олон хөвгүүдтэй байсан хэдий ч Иосеф хүүдээ илүү хайртай байжээ. Иаков насан өндөр болж түүнийг залуу хүү нь л баяр хөөртэй болгодог байлаа.

Иосеф арван ах шигээ биш ээ. Тэд хоорондоо хэрэлдэж, заримдаа бүр аавыгаа хэрэгт хийчихдэг байв. Иосеф их элгэмсэг бас үргэлж үнэнийг ярьдаг байв. Тэр их л баяр хөөртэй байдаг ба аавыгаа ч баяр баясгалантай болгодог нэгэн байлаа.

Иосеф аавынхаа юу хүссэнийг мэдэхээр хурдан явав. Иаков хүүдээ нэгэн гайхалтай бэлэг бэлджээ. Энэ нь маш гоё хүрэм байв. Олон өнгийн утсаар хийгдсэн яг л захирагч эсвэл баян хүний хүрэм шиг л байлаа.

Иосеф хүрмийг гараараа тэмтэрч үзээд "Баярлалаа, ааваа" гэнэ. Тэр ялангуяа тод өнгөнд нь илүү дуртай байв. Иосефын ах нар их л атаархан уурлалаа. Яагаад тэр тийм онцгой байх ёстой гэж? Яагаад тэр л дандаа

ааваас бэлэг авдаг юм? Атаархуу ах нар нь их л бухимдуу ууртай байв.

Нэгэн шөнө Иосеф хачин зүүд зүүдэллээ. Дараагийн өдөр нь тэр ах нартаа зүүдээ ярьжээ. "Бид тариалангийн талбайд тариа боож байна гэнэ. Миний боосон тариа босоод та нарын боосон тариа миний

тарианы өмнө сөгдөж байна" гэж зүүдэллээ гээд хэлчихэв.

"Бид чиний өмнө хэзээ нэгэн өдөр сөгдөх болно гэж чи бодоод байгаа юм уу?" гэж ах нар нь хэлээд бүр ч их бухимдлаа.

Дараа нь, Иосеф өөр нэгэн зүүд зүүдэллээ. "Миний өмнө нар, сар, 11 одод бөхийн ёслол байна гэж зүүдэллээ" гэхэд

аав нь түүнийг чимээгүйхэн зэмлэв. "Аав ээж ах нар чинь үнэхээр чиний өмнө сөгдөх болно гэж чи бодож байна уу?" гэж Иаков асуулаа. Иосефын зүүдний утгыг хэн ч ойлгосонгүй. Гэвч аав Иаков нь мартаагүй, хэдэн жилийн дараа тэр учрыг нь ойлгох болно.

Иосеф Их Эзэнээс олон бэлгээр ивээгдсэн байлаа. Хэзээ нэгэн өдөр ойлгогдох зүүдийг хүртэл Их Эзэн түүнд бэлэглэв. Их Эзэн Иосефын санааг чиглүүлж түүнд сайн сайхан бодол өгч байжээ.

Их Эзэн чамайг ч мөн олон зүйлээр ивээж байдаг. Тэр чамд сайн сайхан бодлыг ч өгдөг. Та нарыг зөвт зүйл хийхэд чинь Тэр үргэлж туслах болно.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ давтахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

Их ЭзэнДээш заах.

Өөрөөс ньДээш заах.

гуйсан хүн бүртАлгаа залбирч байгаа мэт нийлүүлэх.

сайныг өгнө.Гараа нийлүүлэн алгаа дээш нь харуулаад хүнээс бэлэг авч буй мэт биеэсээ урагш болгоно.

Матай 7:11Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням


Эхлэл 37:1-11-г уншин асуух нь: Иосеф хэдэн настай байсан бэ? 17 хүртэл тоолох дасгал хий. Иосефын ах нар түүний тухай юу гэж бодож байсан бэ? Яагаад?

Хүүхдээрээ зөвхөн ганцхан өнгө ашиглуулан буддаг номын нэг зургийг будуулаарай. Дараа нь асуух нь: Зураг чинь ямар харагдаж байна вэ? Их Эзэн олон өнгийг бүтээсэн гэдэгт чи баяртай биш байна гэж үү?

Хүүхэдтэйгээ хамт гадуур алхаж Их Эзэний бэлэглэсэн байгалын янз бүрийн өнгөтэй зүйлийг харуул.

Даваа

Өнгө нэрлээд нэрлэсэн өнгөний чинь өнгөтэй 3 зүйлийг хүүхдээрээ олуул. Өөр янз бүрийн өнгө нэрлээрэй.



Мягмар

Талархлын дуу дуулаад хүүхэд тань юунд хамгийн их талархаж байгаагаа нэрлэхэд нь туслаарай.

Их Эзэний танд өгсөн хамгийн сайхан бэлэгнийхээ тухай ярьж өг. (Таны хүүхэд гэх мэт). Их Эзэнд талархахдаа хүүхдээ тэврээрэй.



Лхагва

Иосефын зүүдийг дүрслэн зур: Нэг боодол ургацын өмнө 11 боодол бөхийж буй ургац, нар, сар, 11 од Иосефын урд бөхийж байгаа нь.

Шөнө болоход сар болон оддыг хар. Тэд ямар хол байдгийг, нар ямар халуун байдгийг, сар өөрөөсөө гэрэл ялгаруулдаггүй ба нарнаас хуримтлуулж авдаг тухай ярьж өгөөд Их Эзэнд тэдгээрийн төлөө талархаарай.

Пүрэв

Шаббат хичээл дээр хийсэн гоёлын хувцсаа хэн нэгэнтэй хуваалцаад тэдэнд хичээл дээр үзсэн түүхээ ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуул. Их Эзэнээс өгөгдсөн тэдний хамгийн дуртай бэлэг нь хувцасны ард бичигдсэн байгаа. Юу болохыг асуугаарай.

Зарим өнгөнүүдийг нэрлээд тоол. Иосефын хувцас ямар өнгөтэй байсан гэж чи бодож байна вэ?

Баасан

Оройн залбирлын үеэр гэр бүлтэйгээ хамт Библийн түүхийг жүжиглэн тоглоорой. Их Эзэний бэлгийг магтсан дуу дуул. Их Эзэнд хайрынх нь болон бидэнд өгдөг бэлэгнийх нь төлөө талархаарай. Гэр бүлийн гишүүн болгон онцгой нэгэн бэлгийг нэрлэх хэрэгтэй.